



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 09 сарын 08 өдөр

Дугаар А/208

Мандалговь

Зардал гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6."а", Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, аймгийн Онцгой комиссын 2020 оны 15 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Шинэ коронавирус (КОВИД-19)-ийн халдвараас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд 19 сургууль, 22 цэцэрлэгийн халдвар хамгааллын дэглэмийг сахиулах арга хэмжээнд дэмжлэг үзүүлэх зорилгоор тус бүр 150000 (нэг зуун тавин мянга)-н төгрөг, нийт 6150000 (зургаан сая нэг зуун тавин мянга)-н төгрөгийг зарцуулсугай.

Хоёр. Нийт 41 сургууль, цэцэрлэгт шинэ коронавирус (КОВИД-19)-ийн халдвараас урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд зарцуулах 6150000 (зургаан сая нэг зуун тавин мянга)-н төгрөгийг аймгийн онцгой комисс-д төвлөрсөн хандив тусламжийн зардлаас зарцуулахыг аймгийн Онцгой байдлын газрын дарга, хурандаа (М.Адъяабаатар)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА  О.БАТ-ЭРДЭНЭ



482010584